

УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР, ТАГНУУЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР,
ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА НАРЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2021 оны дугаар сарын өдөр

Дугаар

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.18 дахь хэсэгт заасныг үндэслэн ТУШААХ нь:

1.“Халдвар авсан иргэний хөдөлгөөнийг тогтоох зорилгоор иргэн, хуулийн этгээдээс мэдээ, мэдээлэл авах журам”-ыг хавсралтаар баталсугай.

2.Журмыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг прокурор, тагнуул, цагдаагийн байгууллагын харьяа алба, нэгж, нутаг дэвсгэрийн байгууллагын дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3.Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Улсын Ерөнхий Прокурорын /...../, Тагнуулын ерөнхий газрын /...../, Цагдаагийн ерөнхий газрын Тэргүүн дэд дарга /цагдаагийн хурандаа Ц.Ням-Очир/ нарт тус тус даалгасугай.

4.Тушаалыг улсын нэгдсэн бүртгэлд бүртгэсэн өдрөөс эхлэн мөрдсүгэй.

УЛСЫН ЕРӨНХИЙ
ПРОКУРОР, ТӨРИЙН
ХУУЛЬ ЦААЗЫН ТЭРГҮҮН
ЗӨВЛӨХ

ТАГНУУЛЫН ЕРӨНХИЙ
ГАЗРЫН ДАРГА, ХУРАНДАА

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ
ГАЗРЫН ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА

Б.ЖАРГАЛСАЙХАН

П.ОДОНБААТАР

Ж.БОЛД

Улсын ерөнхий прокурор,
Тагнуулын ерөнхий газар,
Цагдаагийн ерөнхий газрын дарга
нарын 2021 оны дугаар сарын
өдрийн дугаар хамтарсан
тушаалын хавсралт

**ХАЛДВАР АВСАН ИРГЭНИЙ ХӨДӨЛГӨӨНИЙГ ТОГТООХ
ЗОРИЛГООР ИРГЭН, ХУУЛИЙН ЭТГЭЭДЭЭС
МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ АВАХ ЖУРАМ**

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахал /цаашид “цар тахал” гэх/-аас урьдчилан сэргийлэх, халдвар авсан иргэний хөдөлгөөнийг тогтоох зорилгоор иргэн, хуулийн этгээдээс мэдээ, мэдээлэл авах харилцааг зохицуулахад оршино.

1.2.Иргэн, хуулийн этгээдээс мэдээ, мэдээлэл авах харилцаанд Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан зарчмаас гадна дор дурдсан зарчмыг баримтална:

1.2.1.хууль дээдлэх, хүний эрх чөлөөг хүндэтгэх;

1.2.2.нууцыг чанд хадгалах;

1.2.3.олон нийтийн итгэл хүндлэл, дэмжлэг авах;

1.2.4.иргэн, хуулийн этгээдээс авсан мэдээ, мэдээллийг хуульд зааснаас бусад зорилгоор ашиглахгүй байх.

1.3.Энэхүү журмыг Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн үйлчлэх хугацаанд дагаж мөрдөнө.

Хоёр.Иргэн, хуулийн этгээдээс мэдээ, мэдээлэл авах

2.1.Цар тахлын үед эрүүл мэндийн байгууллага хавьтал тогтоох ажиллагааг зохион байгуулж, халдвар авсан иргэний хөдөлгөөнийг илрүүлэх ажлыг тагнуул, цагдаагийн байгууллага хамтран гүйцэтгэнэ.

2.2.Эрүүл мэндийн байгууллагаас халдвар авсан иргэний холбогдох мэдээ, мэдээллийг тагнуул, цагдаагийн байгууллагад харилцаа холбооны хэрэгслээр, эсхүл цахимаар болон албан бичгээр даруй хүргүүлнэ.

2.3.Цар тахлын үед халдвар авсан иргэний хөдөлгөөнийг тогтоох зорилгоор хавьтагчийн овог, нэр, гэрийн хаяг, утасны дугаар, ажлын хаяг болон бусад шаардлагатай мэдээ, мэдээллийг зөвхөн тагнуул, цагдаагийн байгууллагын алба хаагчийн хүсэлтийг үндэслэн иргэн, хуулийн этгээдээс амаар, харилцаа холбооны хэрэгслээр, эсхүл цахимаар болон бичгээр гаргуулан авна.

2.4.Хүсэлтийг хүлээн авсан иргэн, хуулийн этгээд нь холбогдох мэдээ, мэдээллийг даруй гаргаж өгөх үүрэгтэй бөгөөд аливаа хэлбэрээр саад учруулахыг хориглоно.

2.5.Тагнуул, цагдаагийн байгууллагын алба хаагч нь иргэн, хуулийн этгээдээс мэдээ, мэдээлэл авахдаа зорилго, ач холбогдол, учрах эрсдэл болон хүлээлгэх хариуцлагын талаар тайлбарлана.

2.6.Иргэнээс өгсөн мэдээ, мэдээллийг нарийвчлах, үйл явц, баримтыг бодитой болгох зорилгоор асуултыг асууж, тайлбар авч, тэмдэглэнэ.

2.7.Насанд хүрээгүй хүн, хараа, сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй хүнээс мэдээ, мэдээлэл авахдаа сурган хүмүүжүүлэгч, эсхүл эцэг, эх, гэр бүлийн гишүүн, төрөл садангийн хүн, хэлмэрчийг тус тус заавал байлцуулна.

2.8.Шаардлагатай тохиолдолд дуу авиа, дүрсний бичлэгийн төхөөрөмж ашиглан мэдээ, мэдээллийг бэхжүүлэн авч болно.

2.9.Үүрэн холбооны үйлчилгээ эрхлэгч хуулийн этгээд нь тагнуул, цагдаагийн байгууллагаас ирүүлсэн хүсэлтийн дагуу холбогдох мэдээ, мэдээллийг шууд гаргаж өгнө.

2.10.Иргэн, хуулийн этгээдээс авсан мэдээ, мэдээллийн талаар тагнуул, цагдаагийн байгууллагаас тухай бүр холбогдох прокурорт мэдэгдэж, энэ талаар прокурор бүртгэл хөтөлж, хяналт тавина.

2.11.Тагнуул, цагдаагийн байгууллага иргэн, хуулийн этгээдээс авсан мэдээ, мэдээллийг эрүүл мэндийн болон бусад байгууллагатай солилцож, хамтран ажиллана.

Гурав.Бусад

3.1.Иргэн, хуулийн этгээдээс авсан мэдээ, мэдээллийг энэ журамд зааснаас бусад зорилгоор ашиглах, бусдад ашиглуулах, шилжүүлэхийг хориглоно.

3.2.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 34.2 дахь хэсэгт зааснаар мэдээ, мэдээлэл өгсөн иргэн, хуулийн этгээдэд мөнгөн урамшуулал олгож болно.

3.3.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 35.2 дахь хэсэгт зааснаар иргэн, хуулийн этгээдээс мэдээ, мэдээллийг төлбөртэй авч болно.

3.4.Иргэн, хуулийн этгээдээс мэдээ, мэдээлэл авах үйл ажиллагаанд цугларсан баримт бичгийг архив, албан хэрэг хөтлөлтийн хууль тогтоомжид зааснаар хадгалж, шийдвэрлэнэ.

3.5.Энэ журмыг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага, албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага тус тус хүлээлгэнэ.